



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР

НИЙСЛЭЛИЙН ХӨГЖЛИЙН 2026 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНД
ТУСГАГДСАН АРГА ХЭМЖЭЭНИЙ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН
ХЭРЭГЖИЛТ

УЛААНБААТАР ХОТ
2026 он

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР

НИЙСЛЭЛИЙН ХӨГЖЛИЙН 2026 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНД ТУСГАГДСАН АРГА ХЭМЖЭЭНИЙ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ХЭРЭГЖИЛТ

2026 оны 05 дугаар сарын 29

Улаанбаатар хот

Нийслэлийн хөгжлийн 2026 оны төлөвлөгөөнд байгууллагын үндсэн чиг үүргийн хүрээнд хэрэгжүүлэх 1 зорилт 18 арга хэмжээний тусгагдаж, 2026 оны эхний хагас жилийн байдлаар 78,0 хувийн үзүүлэлттэй "Үр дүн хүлээгдэж байгаа" хэрэгжсэн. Үүнд:

ГУРАВ. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО

3.4 Улаанбаатар хотын онцлог бүхий аялал жуулчлалыг хөгжүүлж, зорин ирэх жуулчдын тоог нэмэгдүүлэх, жуулчдын ая, духтай аялах, зорчих нөхцөлийг бүрдүүлнэ.

Үндсэн үйл ажиллагаа, төсөл, арга хэмжээ 1: Аялал жуулчлалын мэдээлэл сурталчилгааны төвийг нэмэгдүүлж, үйл ажиллагааг үргэлжлүүлэх

Хэрэгжилт: Гадаад, дотоодын иргэд, жуулчдад хэрэгцээт мэдээ мэдээлэл, зөвлөгөө өгөх зорилготой жуулчны мэдээлэл сурталчилгааны төвүүдийг Жанжин Д.Сүхбаатарын талбай, Төв шуудан, "Чингис хаан" олон улсын нисэх онгоцны буудал, ХБНГУ-ын Фрайбург хотод байрлах "Монголын соёл, аялал жуулчлал, мэдээлэл, худалдааны төв", болон "Тэрэлж Монгол олле", "Хонхор тосгон Монгол олле", "Сөүлийн гудамж Монгол олле" "Урухан" брэндийн гэр мэдээллийн төв зэрэг нийт 8 байршилд тогтмол болон улирлын чанартай ажиллуулж байна.

Жуулчны мэдээлэл сурталчилгааны төвийг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд "Чойжин" жуулчны гэр мэдээллийн төвтэй хамтран ажиллах санамж бичиг байгуулан үйл ажиллагаагаа өргөжүүлж, мөн Жуулчны гудамжид байрлах "Урт цагаан" үйлчилгээний төвийн нэг давхарт жуулчны мэдээлэл, сурталчилгааны төвийг шинээр байгуулахаар бэлтгэлийг ханган ажиллаж байна.



Ж.СҮХБААТАРЫН ТАЛБАЙ



ЧИНГИС ХААН ОЛОН
УЛСЫН НИСЭХ БУУДАЛ



ХБНГУ-ЫН ФРАЙБУРГ
ХОТЫН ТӨВ



ТӨВ ШУУДАН



"СӨҮЛИЙН ГУДАМЖ
МОНГОЛ ОЛЛЕ"



"ХОНХОР ТОСГОН МОНГОЛ
ОЛЛЕ"



"ТЭРЭЛЖ МОНГОЛ ОЛЛЕ"



УРУХАН ГЭР
МЭДЭЭЛЛИЙН ТӨВ

Үндсэн үйл ажиллагаа, төсөл, арга хэмжээ 2: Улаанбаатар өвлийн наадам", "Улаанбаатарын өвлийн явган алхалтын фестиваль", "Бүргэдийн баяр", "Наурызын баяр", "Тэнгэр олон улсын бөөгийн фесттваль", "Талын салхи" олон улсын мото наадам", "Бурхан багшийн дүйчин өдөр", "Нийслэл Улаанбаатар хотын иргэдийн өдөр -Хүрээ цам даншиг наадам", "Дээлтэй Монгол" наадам, "Плэйтийм" олон улсын хөгжмийн наадам, "Улаанбаатар олон улсын явган алхалтын фестиваль", "Мянган морьтны фестиваль", "Хийморь" олон улсын морьт харвааны тэмцээн, Фото зургийн фетиваль, "Чингис хааны мэндэлсэн өдөр" хаапын чуулбар арга хэмжээг зохион байгуулах

Хэрэгжилт: "Монголд зочлох жил"-ийн хүрээнд Улаанбаатар хотын аялал жуулчлалыг хөгжүүлэх, жуулчдад зориулсан бүтээгдэхүүн, үйлчилгээг нэмэгдүүлэх, үндэсний ёс заншил, өв уламжлалаар дамжуулан гадаад, дотоодын жуулчдыг татах зорилгоор төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодтой хамтран "Талын Жавхаа", "Улаанбаатарын өвлийн наадам", "Улаанбаатар өвлийн явган алхалтын фестиваль", "Бүргэдийн баяр", "Наурызын баяр", "Плэйтийм пре эвент" хөгжмийн наадам, "UB food" олон улсын хоолны фестиваль зэрэг 7 арга хэмжээг тайлант хугацаанд зохион байгуулсан.

Зохион байгуулсан арга хэмжээ



Талын жавхаа



Улаанбаатарын өвлийн наадам



Улаанбаатар өвлийн явган алхалтын фестиваль



Бүргэдийн баяр



Наурызын баяр



"Плэйтийм пре эвент"




"UB food"

"Талын жавхаа"

Улаанбаатар хотод өвлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх, иргэд, жуулчдын сонирхолд нийцсэн бүтээгдэхүүн үйлчилгээг нэмэгдүүлэх, адууны өв соёлыг таниулан сурталчлах зорилгоор "Талын жавхаа" арга хэмжээг Монголын адуучдын холбоотой хамтран "Чингис Хааны Хүрээ" аялал жуулчлалын цогцолборт 2026 оны 01 дүгээр сарын 24-ний өдөр зохион байгууллаа.

"Талын Жавхаа" адуучны тэмцээнд нийслэлийн Багануур, Багахангай, Баянзүрх, Хан-Уул, Сонгинохайрхан, Сүхбаатар дүүргүүд, Архангай, Булган, Дархан-Уул, Дорноговь, Дорнод, Дундговь, Хэнтий, Төв, Орхон, Өвөрхангай, Сүхбаатар, Сэлэнгэ, Увс зэрэг 13 аймгаас нийт 150 адуучин оролцож, уурга, ташуур шүүрэх, эмнэг булгиулах, морь уургалах, бугуйлдах тэмцээн зохион байгуулагдав.

Арга хэмжээний үеэр адуучдын парад, урлагийн тоглолт, Монгол бүжгийн флаш моб үзүүлбэр зохион байгуулагдаж, хамгийн сайхан үндэсний дээл, хувцастай оролцогчийг шалгаруулан мөн Монгол үндэсний ахуй өвөл цагийн адуу маллах соёлтой танилцах болон морь, морин чарга уналга, гар урлалын худалдаа, үйлчилгээг зохион байгуулж, арга хэмжээг гадаад, дотоодын иргэд, жуулчид нийт 3000 гаруй хүн үзэж сонирхсон.



"Улаанбаатарын өвлийн наадам"

Улаанбаатар хотод өвлийн болон тусгай сонирхлын аялал жуулчлалыг хөгжүүлэх, өвлийн улиралд Улаанбаатар хотод ирэх жуулчдын тоог нэмэгдүүлэх, иргэдийн амралт, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, үндэсний тоглоом наадгай болон орчин үеийн экстрим спортыг түгээн дэлгэрүүлэх зорилгоор 14 дэх удаагийн "Улаанбаатарын өвлийн наадам" арга хэмжээг "Скай резорт" цанын баазад 2026 оны 01 дүгээр сарын 31, 02 дугаар сарын 01-ний өдрүүдэд зохион байгуулав.

“Улаанбаатар өвлийн наадам” арга хэмжээний хүрээнд Мөсөн сурын олон улсын аварга шалгаруулах тэмцээн, Мөсний шагайн улсын аварга шалгаруулах тэмцээн, Параглайдингийн (уулын шүхэр) Улаанбаатар хотын аварга шалгаруулах тэмцээн, Снеүбоардын Улаанбаатар хотын аварга шалгаруулах тэмцээн, Уулын цанын Улаанбаатар хотын аварга шалгаруулах тэмцээн, Кёрлингийн Улаанбаатар хотын аварга шалгаруулах тэмцээн, “Grand tour winter cup 2026” аялал жуулчлалын салбарын оюутнууд дундах буухиа тэмцээн зэрэг 7 төрлийн уралдаан тэмцээнд ОХУ-ын Бүгд найрамдах Буриад улс, Бүгд найрамдах Тува улс, Бүгд найрамдах Халимаг улс, БНХАУ-ын ӨМӨЗО, Шинжаан Уйгур, БНКазахстан Улс, АНУ зэрэг улсаас 46, Монгол Улсын 21 аймаг болон Улаанбаатар хотоос 1500 гаруй хүн оролцлоо.

Арга хэмжээний үеэр иргэд, сонирхогчдын дунд мөсөн хана авиралтын тэмцээн зохион байгуулж, мөн параглайдингийн үзүүлбэр, шувуулахуйн үзүүлбэр танилцуулга, банхар нохдын үзүүлбэр танилцуулга, цана чарганы үйлчилгээ, хоол ундны үйлчилгээ, цаа буга, морь, тэмээ унах үйлчилгээг зохион байгуулж арга хэмжээг гадаад, дотоодын иргэд, жуулчид нийт 15,000 гаруй хүн үзэж сонирхлоо.





"Улаанбаатарын өвлийн явган алхалтын фестиваль"

Улаанбаатар хотод өвлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх, жуулчны улирлын хугацааг уртасгах зорилгоор Монголын явган алхалтын холбоотой хамтран "Улаанбаатарын өвлийн явган алхалтын фестиваль-2026" арга хэмжээг 2026 оны 03 дугаар сарын 07,08-ны өдрүүдэд Горхи-тэрэлжийн байгалийн цогцолборт газарт байрлах "Чингис 21" жуулчны баазад зохион байгууллаа.

Фестивальд АНУ, Нидерланд Улс (Голланд), БНЧУ, БНСУ, БНХАУ зэрэг 5 улсаас 50 гаруй алхагч, "Монголын явган алхалтын холбоо"-ны салбар холбоод 21 аймаг, нийслэлийн дүүргүүдийн төлөөлөгчид, явган алхалтын клубүүдийн нийт 600 гаруй алхагчид оролцов.

Арга хэмжээний үеэр олон улсын стандартын дагуу тэмдэг, тэмдэглэгээг бүрэн байршуулж тохижуулсан "Чингис-21" явган алхалтын замын нээлтийн үйл ажиллагааг зохион байгуулж, оролцогчид шинэ маршрутаар 5 км явган алхалт хийж, мөн оролцогчдын дунд мөсөн сурын тэмцээн, олс таталтын тэмцээн зохион байгууллаа.





"Бүргэдийн баяр"

Казах түмний ёс заншил, өв уламжлал, соёлыг сурталчлан таниулах, бүргэдээр ан хийх дахин давтагдашгүй өвөрмөц соёлоор дамжуулан гадаад, дотоодын жуулчдыг татах, өвлийн улиралд Улаанбаатар хотод зорин ирэх жуулчдын тоог нэмэгдүүлэх зорилгоор "Бүргэдийн баяр-2026" арга хэмжээг 2025 оны 03 дугаар сарын 07,08-ны өдрүүдэд "Чингис хааны хүрээ" аялал жуулчлалын цогцолборт зохион байгууллаа.

"Бүргэдийн баяр-2026" арга хэмжээнд Бүгд Найрамдах Казахстан Улсаас 7, Бүгд Найрамдах Киргиз Улсаас 2, Оросын Холбооны Улсаас 1, Испанийн Хаант Улсаас 3, Унгар улсаас 1, Баян-Өлгий аймгаас 21, Төв аймгаас 1, Сэлэнгэ аймгаас 1 нийт 37 бүргэдчин дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд оролцлоо.

Арга хэмжээний үеэр бүргэдтэй парад, бүргэдүүдийг танилцуулж алдаршуулах арга хэмжээ болон бүргэдчидийн дунд бүргэдээр шьрга (хиймэл ан) бариулах тэмцээн, бүргэдээ хэрхэн сайн сургасан байдлыг шалгаруулах тэмцээн, Казак үндэсний тоглоом көкбар (тулам булаалдах) тэмцээн, зоос шүүрэх тэмцээнүүдийг зохион байгууллаа.

Мөн “Морьтон баатруудын шоу тоглолт”, “Шувуулахуйн үзүүлбэр”, “Шүхрийн үзүүлбэр” болон тойрон бүжиг, цаа буга, тэмээ, морь унах, бүргэд шувуу болон тэмээтэй зураг даруулах болон жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчийн үзэсгэлэн худалдаа, урлагийн тоглолт зэрэг арга хэмжээг зохион байгуулж гадаад, дотоодын иргэд, жуулчид нийт 13,000 гаруй хүн үзэж сонирхов.






“Наурызын баяр”

ЮНЕСКО-ийн хүн төрөлхтний соёлын биет бус өвийн жагсаалтад бүртгэгдсэн “Наурызын баяр”-ын өдрийг тохиолдуулан Казах түмний ёс заншил, өв уламжлал, соёлыг сурталчлан таниулах, түгээн дэлгэрүүлэх, аялал жуулчлалын бүтээгдэхүүн болгон хөгжүүлэх зорилгоор Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Баян-Өлгий аймгийн нутгийн зөвлөлтэй хамтран “Наурызын баяр-2026” арга хэмжээг 2026 оны 03 дугаар сарын 22-ны өдөр жанжин Д.Сүхбаатарын талбайд зохион байгууллаа.



Арга хэмжээний үеэр Казак хувцастай иргэдийн баярын жагсаал, Казак түмний соёл, ёс заншил, ахуйг таниулсан 6 гэр үзэсгэлэн, Казак түмний уламжлалт хоол, ундаа, жижиг дунд үйлдвэрлэгчдийн үзэсгэлэн худалдаа, Казак хувцастай гэр бүл, хос шалгаруулах тэмцээн, Курэс үндэсний бөхийн тэмцээн, Казакийн уламжлалт наадгай Алты бахан /савлуур/ болон урлагийн тоглолт зэрэг арга хэмжээнүүдийг зохион байгуулж, гадаад, дотоодын иргэд, жуулчид нийт 10,000 гаруй хүн үзэж сонирхсон.



“Плэйтайм пре эвент” хөгжмийн наадам

Орчин үеийн хөгжмийн урлагаар дамжуулан Улаанбаатар хотыг олон улсад сурталчлах, гадаад, дотоодын иргэд, жуулчдын сонирхлыг татах бүтээгдэхүүн, үйлчилгээг хөгжүүлэх, жуулчдын тоог нэмэгдүүлэх зорилгоор “Плэйтайм пре эвент” хөгжмийн наадмыг 2026 оны 04 дугаар сарын 12-ны өдөр жанжин Д.Сүхбаатарын талбайд зохион байгууллаа.

Арга хэмжээнд амьд хөгжмийн 4 хамтлаг дуучид уран бүтээлээ хүргэж нийт гадаад, дотоодын иргэд, жуулчид 3,000 гаруй хүн үзэж сонирхсон.



"UB food" олон улсын хоолны фестиваль

Улаанбаатар хотын аялал жуулчлалыг хөгжүүлэх, шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгох, хотын соёлыг түгээн дэлгэрүүлэх, үндэсний болон олон улсын хоолыг олон нийтэд таницлан сурталчлах, иргэдийн амралт, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх зорилгоор "Улаанбаатар фүүд фестиваль 2026" арга хэмжээг 2026 оны 04 дүгээр сарын 17-26-ны өдрүүдэд жанжин Д.Сүхбаатарын талбайд зохион байгуулав.

Фестивальд Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхэлдэг "Silk Road", "Asiana", "Bravo", "Dugbe haous", Маханд дуртай мангас, Арт гэр зэрэг 30 ААНБ, Бүгд Найрамдах Азербайжан Улс, Бүгд Найрамдах Казахстан Улс, Бүгд Найрамдах Узбекистан Улсаас мэргэжлийн тогооч нар хүрэлцэн ирж оролцсон бөгөөд нийт 18 улсын үндэстний хоолоор үйлчилсэн.

Арга хэмжээний өдрүүдэд "Улаанбаатар театр"-ын жран бүтээлчдийн тоглолт, амьд хөгжмийн тоглолт, хамтлаг, дуучид, уран бүтээлчдийн тоглолт болон DJ үзүүлбэр, Open Mic, Magic Mascot, хоолны шоу үзүүлбэр, үзэгчдийн дунд хөгжөөнт тэмцээн уралдаануудыг зохион байгуулж, арга хэмжээг гадаад, дотоодын нийт 108,000 гаруй иргэд жуулчид үзэж сонирхсон.



Аялал жуулчлалын эвент арга хэмжээний хуваарийн дагуу 2026 оны 05 болон 06 дугаар саруудад "Бурхан багшийн дүйчин өдөр", "Талын салхи" олон улсын мото фестиваль, "Тэнгэр" олон улсын бөөгийн фестиваль, "Нийслэл Улаанбаатар хотын иргэдийн өдөр -Хүрээ цам даншиг наадам" зэрэг 4 арга хэмжээг зохион байгуулахаар бэлтгэлийг ханган ажиллаж байна.

Зохион байуулах арга хэмжээ



"Бурхан багшийн дүйчин өдөр"



"Талын салхи"



"Тэнгэр" фестиваль



Хүрээ цам даншиг наадам

Үндсэн үйл ажиллагаа, төсөл, арга хэмжээ 3: Улаанбаатар хотын тойрон аяллын "Сити тур" төслийг үргэлжлүүлэх

Хэрэгжилт: Улаанбаатар хотын түүх, соёл, байгалийн нөөцөд тулгуурлан аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээг нэмэгдүүлэх, гадаад дотоод жуулчдын хэрэгцээнд нийцсэн хотын аяллын бүтээгдэхүүнийг хөгжүүлэх зорилгоор "Сити тур" төслийг хэрэгжүүлэн хот болон хот орчмын 8 удаагийн аяллаар нийт гадаад, дотоодын 400 гаруй хүнийг хотын аялалд хамруулж, 4,263,385 (дөрвөн сая хоёр зуун жаран гурван мянга гурван зууг наян тав) төгрөгийн орлого төвлөрүүллээ.



Үндсэн үйл ажиллагаа, төсөл, арга хэмжээ 4: Өвлийн улиралд жуулчдад хөнгөлөлттэй үнээр үйлчлэх байгууллагуудын тоог нэмэгдүүлэх замаар аялал жуулчлалын улирлын хугацааг уртасгах

Хэрэгжилт: Улаанбаатар хотод өвлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх, жуулчдын улирлын хугацааг уртасгах, жуулчдад хөнгөлөлттэй үнээр үйлчлэх байгууллагуудын тоог нэмэгдүүлэх зорилгоор "UB WINTER SALE" хөнгөлөлтийн аяныг зохион байгуулж Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхэлж байгаа соёл урлаг, аялал жуулчлал, худалдаа, үйлчилгээний 151 аж ахуйн нэгж, байгууллага 100 гаруй бүтээгдэхүүн, үйлчилгээндээ 1+1 урамшуулал болон 5-70 хувь хүртэл хөнгөлөлт, урамшуулалттай үйлчилгээг иргэд, жуулчдад үзүүлээ.





Үндсэн үйл ажиллагаа, төсөл, арга хэмжээ 5: Үйлчилгээний байгууллагуудын чанар стандартыг сайжруулах арга хэмжээг зохион байгуулах

Хэрэгжилт: Улаанбаатар хотод зочин байршуулах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг зочид буудал, дэн буудал, жуулчны бааз, амралтын газруудад тавигдах ерөнхий шаардлага (MNS 4588:2008, MNS 6043:2019, MNS 6043:2019) стандартын хэрэгжилтийг хангуулах, зөвлөн туслах үзлэг шалгалтыг 2026 оны II улиралд зохион байгуулахаар төлөвлөсөн боловч Монгол Улсын Засгийн газрын 2026 оны "Бизнесийн орчныг дэмжих зарим арга хэмжээний тухай" 127 дугаар тогтоолоор худалдаа, үйлчилгээ эрхлэхтэй холбоотой хууль тогтоомж, зөвшөөрлийн нөхцөл, шаардлагын талаар иргэн, хуулийн этгээдэд мэдээлэл, мэдэгдэл, зөвлөмжийг цахим хэлбэрээр хүргүүлэх, хүндрэл, дарамт учруулахгүй байх заалтын хүрээнд тухайн арга хэмжээг зохион байгуулаагүй болно.

Үндсэн үйл ажиллагаа, төсөл, арга хэмжээ 6: Үйлчилгээний байгууллагуудын чанар стандартыг сайжруулах сургалт зохион байгуулах

Хэрэгжилт: Аялал жуулчлалын үйлчилгээний байгууллагын чанар, хүртээмжийг сайжруулах, салбарын хүний нөөцийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх зорилгоор "Аялал жуулчлалын салбар дахь татвар-даатгал-байгууллагын менежмент, үнэ бодолт" сэдэвт сургалт, "Зочид буудал, дэн буудал, амралтын газар тавигдах ерөнхий шаардлага (MNS 4588:2008, MNS 6043:2019, MNS 6043:2019) стандарт" сэдэвт сургалт, "Гамшгаас урьдчилан сэргийлэх, аюулгүй байдлыг хангах нь" "Жуулчны хөтөч тайлбарлагчид ур чадвар олгох сургалт" зэрэг 4 төрлийн 3 удаагийн сургалтыг зохион байгуулж нийт 328 хүнийг хамруулав.





3D ТАНХИМ
Хугацаа: 20 минут
Суралцагчид хамтаар биеэс биеийн хөдөлгөөнийг ажиглах, 3D танхимын доторх биеэс биеийн хөдөлгөөнийг ажиглах, биеэс биеийн хөдөлгөөнийг ажиглах.

ГАЗАР ХӨДӨЛӨЛТИЙН ТАНХИМ
Хугацаа: 20 минут
Суралцагчид газрын хөдөлгөөнийг ажиглах, газрын хөдөлгөөнийг ажиглах, газрын хөдөлгөөнийг ажиглах.

УТААТ ОРЧНЫ ТАНХИМ
Хугацаа: 20 минут
Суралцагчид утаат орчныг ажиглах, утаат орчныг ажиглах, утаат орчныг ажиглах.

УХ ТАНХИМ
Хугацаа: 20 минут
Суралцагчид ух-ийг ажиглах, ух-ийг ажиглах, ух-ийг ажиглах.

ГАЛЫН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТАНХИМ
Хугацаа: 20 минут
Суралцагчид галын аюулгүй байдлыг ажиглах, галын аюулгүй байдлыг ажиглах, галын аюулгүй байдлыг ажиглах.

ЭМНЭЛГИЙН АНХАН ШАТНЫ ТУСЛАМЖИЙН ТАНХИМ
Хугацаа: 20 минут
Суралцагчид эмнэлгийн анхан шатны тусламжийг ажиглах, эмнэлгийн анхан шатны тусламжийг ажиглах, эмнэлгийн анхан шатны тусламжийг ажиглах.

БАГА НАСНЫ ХҮҮХДИЙН ТАНХИМ
Хугацаа: 20 минут
Суралцагчид бага насны хүүхдийн танхимийг ажиглах, бага насны хүүхдийн танхимийг ажиглах, бага насны хүүхдийн танхимийг ажиглах.

АЮУЛГҮЙ ӨРХИЙН ТАНХИМ
Хугацаа: 20 минут
Суралцагчид аюулгүй өрхийн танхимийг ажиглах, аюулгүй өрхийн танхимийг ажиглах, аюулгүй өрхийн танхимийг ажиглах.

ЗАХИАГААТ СУРГАЛТ:
"ЭНДЭГ НЭЙ СҮРМЭ ТҮЖИР-ЭН ЧАДАВ, ТН СУРГАА ХАА, ТН ДЭВЭЭНИЙ"
"ГАМШГИЙН ҮДИРДЭЛЭГЭН АНХАН ШАТНЫ"
"ГАЗАР ХӨДӨЛӨЛТ БА ТУРШЛАГА СУРГАМЖ"
Суралцагчид хамтаар сургалтын төлөвлөгөөг ажиглах, сургалтын төлөвлөгөөг ажиглах, сургалтын төлөвлөгөөг ажиглах.

СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР

НИЙСЛЭЛИЙН АНГАЛ **ЖУУРЧАЛЫН ГАЗАР** **ГЭМШГЭЭС ХАМГААЛАХ** **НИЙСЛЭЛИЙН АНГАЛ** **ЖУУРЧАЛЫН ГАЗАР** **ГЭМШГЭЭС ХАМГААЛАХ** **НИЙСЛЭЛИЙН АНГАЛ** **ЖУУРЧАЛЫН ГАЗАР** **ГЭМШГЭЭС ХАМГААЛАХ**

ГАМШГААС ХАМГААЛАХ СУРГАЛТ

2026 оны 02 сарын 12-ний өдөр
08:40 - 12:00 цагт

БГД 20 ДУГААР ХОРОО АЛТАЙ ХОТХОН 77128822, 99959605



Үндсэн үйл ажиллагаа, төсөл, арга хэмжээ 7: Жижиг, дунд бизнес эрхлэгчдийг арга хэмжээнд хамруулах

Хэрэгжилт: Нийслэлийн Засаг даргын 2026 оны А/01 дүгээр захирамжаар 2026 оныг “Бизнес эрхлэгчдийг дэмжих жил” болгон зарласантай холбогдуулан гадаад, дотоодын иргэд, жуулчдад зориулан зохион байгуулсан Талын Жавхаа, “Улаанбаатарын өвлийн наадам”, “Улаанбаатар өвлийн явган алхалтын фестиваль”, “Бүргэдийн баяр”, “Наурызын баяр”, “Плэйтийм пре эвент” хөгжмийн наадам, “UB food” олон улсын хоолны фестиваль зэрэг 7 арга хэмжээний үеэр 143 жижиг, дунд, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн худалдаа, үйлчилгээг гаргаж үйл ажиллагааг нь дэмжин ажилласан.

Мөн Аялал жуулчлалын салбар, үндэсний үйлдвэрлэгчид болон жижиг, дунд бизнес эрхлэгчдийн түншлэл, хамтын ажиллагааг дэмжих зорилгоор Эдийн засаг хөгжлийн яам, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Жижиг, дунд үйлдвэрийн газар, Монголын Аялал жуулчлалын холбоотой хамтран “FEEL MONGOLIA-2026” арга хэмжээг 03 дугаар сарын 27, 28-ны өдрүүдэд зохион байгуулж, арга хэмжээнд үндэсний үйлдвэрлэгчид, үйлчилгээний бизнес эрхлэгчид, соёлын бүтээлч үйлдвэрлэл, эвент арга хэмжээ зохион байгуулагч байгууллагууд, ханган нийлүүлэгчид, зочид буудал, тур оператор зэрэг 250 гаруй аж ахуйн нэгж байгууллага, бизнес эрхлэгчид оролцон үйл ажиллагаагаа сурталчлан танилцууллаа.




Үндсэн үйл ажиллагаа, төсөл, арга хэмжээ 8: Хот, дүүргүүдэд жуулчны зорин очих газар, худалдаа үйлчилгээний гудамж бий болгох

Хэрэгжилт: Жуулчны гудамжны тохижилтын ажил дууссантай холбогдуулан гадаад дотоод иргэд, жуулчдыг татах зорилгоор “Урт цагаан” үйлчилгээний төвтэй хамтран 2026 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс 9 дүгээр сарын 10-ныг хүртэлх хугацаанд худалдаа, үйлчилгээ бүхий жуулчны гудамж бий болгож Баасан, Бямба, Ням гарагуудад олон төрлийн арга хэмжээнүүдийг зохион байгуулахаар төлөвлөж, нийслэлийн удирдлагуудад танилцуулав.

Үндсэн үйл ажиллагаа, төсөл, арга хэмжээ 9: Улаанбаатар хотын танилцуулга сэтгүүл, цахим сэтгүүл, газрын зураг, хөтөч ном, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх контент зэргийг шинэчлэн гаргах

Хэрэгжилт: Нийслэл Улаанбаатар хотыг гадаадад сурталчлах, жуулчдыг хэрэгцээт мэдээ мэдээллээр хангах, олон улсын үзэсгэлэн, арга хэмжээний үеэр ашиглах Улаанбаатар сэтгүүл (Англи, Герман, Япон, Солонгос, Орос, Хятад хэл дээр), Улаанбаатар хотын хөтөч ном (Guide book), жуулчдад зориулсан Улаанбаатар хотын газрын зураг (City map), “Улаанбаатар 360” явган алхалтын хөтөч ном зэрэг 9 төрлийн 30,000 ширхэг сурталчилгааны материалыг хэвлүүлж Монгол Улсад суугаа гадаад улсуудын Элчин сайдын яамд, консулын газрууд, аялал жуулчлалын мэргэжлийн холбоод, Жуулчны мэдээлэл, сурталчилгааны төвүүд болон гадаад, дотоодод зохион байгуулагдсан олон улсын үзэсгэлэн, уулзалт, хурал, зөвлөгөөн, эвент арга хэмжээнүүдэд түгээж Улаанбаатар хотыг сурталчлан ажиллаж байна.








Үндсэн үйл ажиллагаа, төсөл, арга хэмжээ 11: Улаанбаатар хотын аялал жуулчлалын маршрут, зорин очих газрууд, жуулчдад зориулсан онцлох соёл, аялал жуулчлалын арга хэмжээг орчин үеийн дэвшилтэд технологиуд ашиглан хийж гадаад улс оронд сурталчлах


Хэрэгжилт: Улаанбаатар хотын аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээнд орчин үеийн дэвшилтэт технологийг нэвтрүүлж хотын аялал жуулчлалын маршрут, зорин очих газрууд, жуулчдад зориулсан соёл, аялал жуулчлалын арга хэмжээг сурталчлах ажлын хүрээнд мета куэст 3S төрлийн 11 ширхэг Ви Ар (VR) төхөөрөмжөөр 32 бүтээгдэхүүн үйлчилгээнд VR 360 зураг авалт хийж, Web AR 3D модель контент хийсэн. Нэмэлтээр Улаанбаатар хотын 20 гаруй бүтээгдэхүүн, үйлчилгээний Ви Ар зураг авалтыг нэмж хийх, веб хуудаснаас үзэх боломжтой болгохоор программ шинэчлэлтийн ажлыг зохион байгуулахаар ажиллаж байна.





Үндсэн үйл ажиллагаа, төсөл, арга хэмжээ 12: Жуулчдад зориулсан гар утасны аппликейшн хөгжүүлэх

Хэрэгжилт: Жуулчдад зориулсан гар утасны аппликейшн арга хэмжээний хүрээнд гадаад, дотоодын жуулчдад зориулсан www.visit-ulaanbaatar.com веб хуудас болон Visit Ulaanbaatar аппликейшнд голлох зах зээлийн орнууд буюу (япон, солонгос, хятад, орос) хэлний сонголтыг цэс хэсэгт нэмж хөгжүүлэлтийг хийж байна. Мөн хөгжүүлэлтээр веб хуудасны хэрэглэгчийн интерфэйс (UI/UX) болон арын систем (Backend)-д техникийн шинэчлэл хийж, 4 улсын хэлний сонголтын модулийг шинээр суулгасан. Хэлний цэсийг веб хуудасны үндсэн нүүрний баруун дээд хэсэгт цэс (Dropdown menu) хэлбэрээр байршууллаа.



Үндсэн үйл ажиллагаа, төсөл, арга хэмжээ 13: Жуулчны аюулгүй байдлыг хангах чиглэлээр контент хийж, жуулчид ихээр зорчдог байршлуудаар сурталчлах

Хэрэгжилт: Жуулчны аюулгүй байдлыг хангах чиглэлээр бүтээсэн видео контентийг голлох зах зээлийн орнуудын хэл дээр (англи, хятад, орос, солонгос) орчуулгыг бүрэн хийж дуусгаж, дууны засюарын ажлыг гүйцэтгэж байна. Энэхүү видео контентуудыг 2026 оны 06 дугаар сараас эхлэн газрын цахим сувгууд байршуулж, мөн Нийслэлийн Цагдаагийн удирдах газар, томоохон худалдааны төвүүд холбогдох аялал жуулчлалын байгууллагуудад хүргүүлж сурталцах ажлыг зохион байгуулахаар ажилалж байна.


Үндсэн үйл ажиллагаа, төсөл, арга хэмжээ 14: Улаанбаатар хотын соёл, аялал жуулчлалын өдрүүдийг зохион байгуулах

Хэрэгжилт: Улаанбаатар хотыг олон улсад сурталчлах зорилгоор аялал жуулчлалын мэргэжлийн холбоод, тур оператор компаниудтай хамтран "Улаанбаатар хотын соёл, аялал жуулчлалын өдрүүд" арга хэмжээг 2026 оны 09 сард зохион байгуулахаар төлөвлөж, бэлтгэлийг ханган ажиллаж байна. Тайлагнах хугацаа болоогүй.

Үндсэн үйл ажиллагаа, төсөл, арга хэмжээ 15: Улаанбаатар хотын аялал жуулчлалын бүтээгдэхүүнийг сурталчлах зорилгоор олон улсын үзэсгэлэнд оролцох, арга хэмжээг зохион байгуулах

Хэрэгжилт: "Монголд зочлох жил"-ийн хүрээнд Монгол Улс, Улаанбаатар хотыг олон улсад сурталчлах, аялал жуулчлалын салбарын өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, зорин ирэх жуулчдын тоог нэмэгдүүлэх зорилгоор төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоод, тур оператор компаниудтай хамтран ХБНГУ-ын Берлин хотноо 2026 оны 03 дугаар сарын 03-05-ны өдрүүдэд зохион байгуулагдсан "ITB Berlin" олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэн, Дэлхийн хотуудын аялал жуулчлалыг дэмжих байгууллага (ТРО)-аас БНСУ-ын Бусан хотноо 2026 оны 05 сарын 11-14-ний өдрүүдэд зохион байгуулсан "TRO Capacity Building Program-2026" олон улсын арга хэмжээ, БНХАУ-ын Тианжин хотноо 2026 оны 05 дугаар сарын 18-19-ний өдрүүдэд зохион байгуулсан "Улаанбаатар -Тианжин" хот хоорондын шууд нислэгийн нээлтийн арга хэмжээ зэрэг зэрэг олон улсын 3 үзэсгэлэн, арга хэмжээнд оролцож үйл ажиллагаагаа сурталчилсан.










Үндсэн үйл ажиллагаа, төсөл, арга хэмжээ 16: Олон улсад алдартай аялагч нартай хамтран ажиллаж, Улаанбаатар хотын аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээг сурталчлах

Хэрэгжилт: Улаанбаатар хотын аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээг цахим сүлжээгээр олон нийтэд сурталчлах ажлын хүрээнд 2026 оны 03 дугаар сарын 07, 08-ны өдрүүдэд Чингис хааны хүрээ аялал жуулчлалын цогцолборт зохион байгуулсан "Бүргэдийн баяр" арга хэмжээг инфлюенср Т.Саруултөгс (Tuugu Saruultugs)-өөр, жанжин Д.Сүхбаатарын талбайд 2026 оны 04 дүгээр сарын 12-ны өдөр зохион байгуулсан "Playtime" олон улсын хөгжмийн наадмын "Pre event" арга хэмжээг М.Ганбаяр инфлюенср (Gremix)-ээр, жанжин Д.Сүхбаатарын талбайд 2026 оны 04 дүгээр сарын 17-26-ны өдрүүдэд зохион байгуулсан "УБ фүүд фестиваль" арга хэмжээг олны танил аялагч, судлаач Ц.Ган-өлзий (аяллын тойрог), Н.Энхбаяр (хоолондоо), Ч.Машнууцсүх (Мангас машаа-Meat-lover Monsters of Mongolia), мастер тогооч Ц.Мэнджаргал (Miko Miko) зэрэг нийт 7 нөлөөлөгчөөр дамжуулан 1 нэвтүүлэг, 8 удаагийн лайв, 31 удаагийн рийлс, 21 удаагийн пост мэдээлэл хийлгүүлж цахим орчинд түгээж, давхардсан тоогоор нийт 5,150,281 хүнд хүргэсэн байна.

Мөн Бүгд Найрамдах Казахстан Улсын инфлюенсэрүүд болон "Physical Asia" нэвтрүүлэгт оролцогч гадаад, дотоодын инфлюенсэрүүдээр дамжуулан Улаанбаатар хотыг сошиал орчинд сурталчилахаар төлөвлөн ажилллаж байна.





Үндсэн үйл ажиллагаа, төсөл, арга хэмжээ 17: Олон улсын хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран олон нийтийн цахим сүлжээгээр Улаанбаатар хотын маркетинг сурталчилгааг хийх

Хэрэгжилт: Улаанбаатар хотын аялал жуулчлалын онцлох бүтээгдэхүүн үйлчилгээг олон улсад сурталчлах зорилгоор Япон Улсын NHK телевизийн "Great nature нэвтрүүлгийн багтай хамтран ажиллаж, нэвтрүүлгийн агуулгад нийцүүлэн зураг авалтын ажлыг хийу дуусган 2026 оны 07 дугаар сард Япон Улсын NHK, Монгол Улсын Монголын үндэсний радио, телевиз, Сүлд ТВ болон Тэнгэр ТВ-үүдээр түгээхээр ажиллаж байна.

БНХАУ-ын ӨМӨЗО-ны улсын хорооны Монгол дахь төлөөлөгчийн газраас бэлтгэн хүргэдэг "Сайн байна уу дундад орон" нэвтрүүлгийн багтай хамтран "Сайн байна уу Монгол орон, Сайн байна уу Улаанбаатар хот" сэдвийн хүрээнд Улаанбаатар хотын аялал жуулчлалын онцлох бүтээгдэхүүн, үйлчилгээг БНХАУ болон ӨМӨЗО-ны иргэдэд 5 цуврал нэвтрүүлэг болгон хүргэхээр төлөвлөж ажиллаж байна.

Үндсэн үйл ажиллагаа, төсөл, арга хэмжээ 18: Улаанбаатар хотыг олон улсад сурталчлах фам турыг хот болон хот орчимд зохион байгуулах

Хэрэгжилт: Улаанбаатар хотыг олон улсад сурталчлах, зорин ирэх жуулчдын тоог нэмэгдүүлэх зорилгоор олон улсын аялал жуулчлалын салбарын шилдэг байгууллагуудын төлөөллийг оролцуулан Улаанбаатар хотын аялал жуулчлалын бүтээгдэхүүн үйлчилгээг сурталчлах фам турыг 2026 III улиралд зохион байгуулахаар бэлтгэлийг ханган ажиллаж байна.

ХЯНАЖ, ТАНИЛЦСАН:
ДАРГА

Д.БАТСҮХ

ХЭРЭГЖИЛТ НЭГТГЭСЭН:

БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ТАЙЛАН, ТОГТООЛ ШИЙДВЭР,
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХЭРЭГЖИЛТ ХАРИУЦСАН АХЛАХ
МЭРГЭЖИЛТЭН

О.НЯМБАТ